

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,
СУМДЫН 2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.04.04

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл 2023 оны 03 дугаар сард 1 удаа хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

1.Хуралдааны тов тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XV хуралдааныг 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хуралдуулахаар товлолоо.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ажлын төлөвлөгөөний төсөл

3.“Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай

4.Бэлгийн замаар дамжих халдварын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаарх мэдээлэл

5.Аймгийн Прокурорын газраас ирүүлсэн албан бичиг танилцуулах

6.Иргэний өргөдлийн тухай

7.Бусад зэрэг асуудлуудыг хэлэлцлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

“Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат шинэ сэргэлтийн бодлого” сургалт манай аймагт зохион байгуулагдаж, сургагч багшаар Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Я.Төмөрбаатар, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч Г.Золбаяр, Удирдлагын академийн Улсын салбарын удирдлагын тэнхимийн эрхлэгч Б.Нарантулга, Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн ахлах багш М.Досымбек, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Сувдаа, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Болортуяа, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Ц.Золжаргал нар ажиллалаа.

Сургалтад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, төр, төсвийн байгууллагын удирдлага, төрийн албан хаагчид, ОНӨААТҮГ-ын дарга, захирлууд зэрэг 200 төлөөлөл оролцож сургагч багшаар бэлтгэгдлээ.

УИХ-ын гишүүн Д.Өнөрболор, аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж болон сум орон нутгийн удирдлагууд БНСУ-ын Үньпёон мужид албан айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж БНСУ-ын Үньпён мужтай хөдөө аж ахуйн салбарыг технологижуулан өргөжүүлж, ухаалаг хүлэмжийг байгуулах, салбарын ажилтан албан хаагчдыг мэргэшүүлж, туршлага судлуулах чиглэлд хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Ерөө сумын төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 200 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг ашиглалтад орж, аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж тус цэцэрлэгийн багш хөгжлийн төвд 45 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам тойрогтоо ажиллаж иргэдтэй уулзан 2020-2023 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээлэл, хэлэлцэн баталсан онцлох хууль тогтоомжийг танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэлээ.

“Чинбатын Ундрам” хөгжлийн сангийн санаачилгаар, ХБНГУ-ын Монгол Улс дахь Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр Сүхбаатар сумын МСҮТ-ийн автомашины засварчин мэргэжлийн дадлагын газар сургалтад ашиглагдах техник тоног төхөөрөмжтэй боллоо.

Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж”-ийн хөтөлбөрийн хүрээнд “Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засварын төсөл”-ийг хэрэгжүүлэхээр боллоо. Япон Улсын Засгийн газар Монгол Улсад 1990 оноос хойш 33 жилийн турш “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж”-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ удаагийн төсөл нь “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн 590 дэх, Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх 26 дахь төсөл болж байна.

Энэхүү төслийн гэрээнд Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Кобаяши болон аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж нар гарын үсэг зурлаа. Төслийн хүрээнд Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засварын ажил хийх юм. Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж”-ийн хөтөлбөрийн хүрээнд “Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засварын төсөл”-ийг хэрэгжүүлэхээр боллоо.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд шалгалтад орохоор 204 иргэн бүртгүүлснээс 186 иргэн шалгалтад орж, 59 иргэн тэнцэж нөөцөд бүртгэгдлээ.

Төрийн албаны тусгай шалгалтыг 3 дугаар сард 2 удаа зохион байгуулж, нийтдээ 126 сул орон тоо зарлагдсанаас 35 сул орон тоог нөхөх арга хэмжээ авлаа.

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/86 дугаар захирамжийн дагуу Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг орон нутгийн удирдлага, байгууллагуудтай хамтран Батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, өсвөр үеийнхэнд цэрэг-эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгууллаа.

Энэ хүрээнд Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын дунд цэрэг-спортын олон төрөлт цуврал тэмцээнийг “Мөрдөстэй бүсгүйчүүд”, “Буудлага”, “Хайрлан дуулах эх орон”, “Волейбол”, “Сагсан бөмбөг”, “Марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг”, ерөнхий боловсролын сургуулиудын 7-12 дугаар ангийн сурагчдын дунд “Монгол Улсын Зэвсэгт хүчин” сэдвээр гар зургийн, “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” сэдвээр Эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж, шилдгүүдийг тодруулан ажилласан.

Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсээс “Төрөөс Стандартчилал, хэмжил зүйн талаар баримтлах бодлого”, “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлтсийн дарга Д.Ган-Отгон “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн төслийг танилцуулан, хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллагын нийт 130 орчим төлөөлөл оролцлоо.

Онцгой байдлын ерөнхий газар, аймгийн засаг даргын Тамгын газар хамтран төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах, аврах ангийн захирагч нарын сургалтыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч нарын манлайлал, ур чадвар, хууль, эрхзүйн мэдлэг, өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүн, албаны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 74 ангийн захирагч хамрагдлаа.

“Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” MASAM-2 төсөл манай аймагт хэрэгжиж байна. Төслийн хүрээнд төсвийн хөрөнгө оруулалт болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний үр дүн, үр ашгийг сайжруулах чиглэлээр төсвийн үйл явцад нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслийг оновчтой хэрэгжүүлэх, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн 4 модуль сургалт төрийн байгууллага, иргэд, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт зохион байгуулагдлаа.

Аймгийн Монгол шуудан үйлчилгээний газар дэргэдээ Монгол маркийн танхимтай боллоо. УИХ-ын гишүүн Ч.Ундрам, Ж.Эрдэнэбат нарын дэмжлэгтэйгээр байгуулагдаж байгаа уг танхим нь Монгол Улсын шуудан үйлчилгээний газрын хэмжээнд анхны Монгол маркийн танхим болж байгаагаараа онцлог юм.

Уг арга хэмжээний үеэр ховор маркийн дуудлага худалдаа зохион байгуулагдлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Жүдо бөхийн холбоо, БТСГ, МЖБХ, “Шинэбадрах” дэвжээ хамтран зохион байгуулж буй “Ирээдүйн одод” Олон Улсын Жүдо бөхийн өсвөрийн аварга шалгаруулах тэмцээн 4 дэх жилдээ Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж 40 гаруй баг, 1200 гаруй тамирчид оролцлоо.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд ой, хээрийн түймрийн 3, объектын гал түймрийн 10, аврах ажиллагааны 2 нийт 15 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч 6 иргэний амь нас, иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 334 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалан ажилласан.

“Дэлхийн иргэний хамгаалалтын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан аймгийн Онцгой байдлын газар Сүхбаатар, Мандал, Сайхан сумдад “Тухайн бүс нутагт зонхилон тохиолддог гамшиг, аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ойлголтыг олгох нь”, “Гал түймрийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх”, “Гамшгийн бэлэн байдал, арга хэмжээ”, “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах”, “Газар хөдлөлт”, “Ахуйн осол”, “Гал түймрийн аюулаас хэрхэн сэргийлэх” сэдвүүдээр 10 удаагийн танхимын сургалтаар нийт 468 ажилтан, алба хаагчдад сургалт зохион байгуулсан.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг тухай бүр цахим хуудаст байршуулж, олон нийтийн сүлжээгээр сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Үзлэг шалгалтын явцад боловсруулсан нийт эрх зүйн бичиг баримт

Үзүүлэлт Он	Шалгалтад хамрагдсан	Зөрчил	Бичсэн эрх зүйн бичиг баримт	ХҮ	НА	УЛ	СЫ
----------------	-------------------------	--------	------------------------------	----	----	----	----

	ААНБ	Айл өрх	ирүүлсэн	Арилгуулсан	ЗБАШ	Мэдэгдэл	Танилцуулга	Дүгнэлт	Акт	АЗТогтоол		
2023.03	31	226	226	18	23	6	-	4	5	-	6	2

Тус сард 7 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж зөрчлийг арилгасан 11 объектод ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож 250.000 төгрөг, төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн барилга байгууламжийн 6 ажлын зургийг хянаж Онцгой байдлын хэлтсийн даргаар баталгаажуулан дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэн 600.000 төгрөгийг тус тус төрийн санд төвлөрүүлсэн.

Сант сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь Галын аюулгүй байдлыг хангаагүй улмаас Зөрчлийн тухай хуулийн 5.14.1 дэх хэсэгт заасны дагуу 100 нэгж буюу 100.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Үйлчилгээний баталгаажуулалт: Ерөө, Сүхбаатар, Шаамар сумын 10 аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээний газрыг тохирлын үнэлгээнд хамруулж “MNS 5021-1:2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага”, “MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” стандартад нийцсэн 8 үйлчилгээний газарт баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж тохирлын гэрчилгээ олгосон. Гаалийн газрын албан хүсэлтээр ирсэн 5 нэрийн 10.1 литр цагаан архи, 1 нэрийн 2.1 литр вискиг итгэмжлэгдсэн сорилтын лабораторид сорилт шинжилгээнд хамруулсан. Мөн 2 иргэн аж ахуйн нэгжийн хэрчсэн гурил, гурилан бүтээгдэхүүний хаяг шошгыг MNS 6648:2016 стандартын шаардлагад нийцүүлэн хийх талаар зөвлөмж өгч ажилласан.

Экспорт баталгаажуулалт: Ерөө суманд “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Инфинити спэйс” ХХК хэмээх 2 аж ахуй нэгжийн олборлодог “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал- MNS 6249:2011” стандартын шаардлагад нийцсэн төмрийн хүдрийн 81 удаагийн тээвэрлэлтэд баталгаажуулалт хийж экспортын гэрчилгээ олгосон байна.

Хэмжих хэрэгсэл шалгалт баталгаажуулалтын 2023 оны гэрээг 6 байгууллагатай шинээр байгуулаад байна.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Сүхбаатар сумын “ГОР ГАЗ” АХЦС-ын, Мандал сумын “Сод Монгол” ШТС-д шинээр 6 хошуутай түгээгүүр суурилуулсан тул дуудлагын дагуу шалган баталгаажуулалтад хамрууллаа.

Шалган тохируулгаар: Шалгалт тохируулгад хамрагдах хэмжих хэрэгслийн нэр төрлийг 1-ээр нэмэгдүүлэн орон нутагтаа автомат пипетка шалгах ажлыг хийж эхлээд байна.

Үүний хүрээнд Мал эмнэлгийн газрын 22 автомат пипеткыг шалган мөн лабораторийн 22 шилэн хэмжүүрт, 1 нөөцлөх саванд шалгалт тохируулга хийлээ.

Массын хэмжлээр: Сүхбаатар сумын худалдаа эрхлэгчдийн болон эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 17 хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулсан.

Дулаан даралтаар: 4 байгууллагын 3 цусны даралтын аппарат, 11 техникийн манометр шалган баталгаажуулсан байна.

Итгэмжлэгдсэн лаборатори нь: 20 аж ахуйн нэгжийн 42 дээжид 172 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийсэн байна. Мөн 19 аж ахуйн нэгжийн 576.400 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Өнгөрсөн 2 сард 709 баримтаар 11,9 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 02 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод байдлын самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		14,134,615.4	8,173,036.8	57.8
1.1	Орон нутгийн төсвийн орлого	8,104,781.4	7,329,712.9	90.4
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	4,785,785.2	6,844,480.6	143.0
	Сумдын төсвийн орлого	3,318,996.2	485,232.3	14.6
1.2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	686,143.6	686,143.6	
1.3	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	400,000	-	-
1.4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	3,823,015.9	-	-
1.5	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	-	-	-
1.6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	636,267.9	-	-
1.7	Сум хөгжүүлэх сангийн орлого	860,239.7	-	-
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		20,068,312.7	6,199,477.9	30.9
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	20,068,312.7	6,199,477.9	30.9
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	13,748,235.3	5,582,835.1	40.6
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	697,556.2	55,692.4	8.0
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	5,622,521.2	560,950.4	10.0
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	680,000.0	-	-
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	1,686,616.6	91,985.1	5.5
	Халамжийн сан	13,200.0	3,600.0	27.3

	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	2,811,260.6	280,475.2	10.0
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	431,444.0	184,890.1	42.9
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	-	-	-
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		686,143.6	686,143.6	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	686,143.6	686,143.6	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	-	-	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	-	-	-
	Усан хангамжийн татаас	-	-	-
4. Тусгай сангуудын зарлага		993,424.6	105,596.5	10.6
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	993,424.6	105,596.5	10.6

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022 – II	2023 – II	<u>2023 - II</u> <u>2022 - II</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа	1 500	2 200	146.7
	Гурил /Алтантариа, I зэрэг, кг/	1 500	2 200	146.7
	Талх /орон нутгийн, ш/	1 400	2 000	142.9
	Нарийн боов /кг/	4 300	5 500	127.9
	Будаа /кг/	3 200	3 600	112.5
	Элсэн чихэр /кг/	3 200	3 500	109.4
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	9 500	9 500	100.0
	Үхрийн мах /кг/	12 000	12 500	104.2
	Адууны мах /кг/	8 500	8 500	100.0
	Ямааны мах /кг/	9 000	8 000	94.4
	Дотор мах, цувдай /цусгүй/	5 000	8 000	160.0
	Хиам /чанасан, кг/	12500	18500	148.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	2 700	3 700	137.0
	Сүү / савласан, л/	3 800	4 800	126.3
	Тараг /задгай, л/	2 500		
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	21 000	25 000	119.0
	Айраг /л/	5 000		

	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	5 500	8 500	154.5
	Өндөг /ш/	400	500	125.0
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	8 100	11 500	142.0
	Өөхөн тос /кг/	3 500	3 000	85.7
	Шар тос /кг/	25 000	25 000	100.0
	Масло /задгай, кг/	6 000	11 000	183.3
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 200	1 500	125.0
	Лууван /кг/	2 500	2 000	80.0
	Манжин /кг/	2 500	2 500	100.0
	Байцаа /кг/	2 800	2 500	89.3
	Сонгино /кг/	2 500	3 000	120.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	6 000	7 500	125.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	4 000	6 200	155.0
2. ШАТАХУУН				
	Бензин А-80	2 350	2 480	105.5
	Бензин А-92	2 400	2 500	104.2
	Дизелийн түлш	2 840	3 910	137.7

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

“Гүрт улам Ундрам” ХХК, “Хүннү Стилл” ХХК, Шаамар сумын Засаг даргын нэхэмжлэлтэй 3 удаагийн захиргааны хэргийн Шүүх хуралд оролцож, холбогдох материалыг гарган өгч хэлэлцүүлсэн.

“Иргэдийн Шударга Шүүх” ТББ-тай хамтран 10 сум, 2 тосгоны иргэд, төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдад Үндсэн хуулийн талаарх ойлголт өгөх чиглэлээр сургалт мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 8 агентлагийн ХАСХОМ тайланг аймгийн хэмжээнд нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Аймгийн Цагдаагийн газар болон холбогдох бусад төрийн байгууллагуудтай хамтран мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Анзаар” арга хэмжээг зохион байгуулж, төрийн байгууллагын 1449 ажилтан албан хаагчид, 5 сургуулийн нийт 742 эцэг эхийн зөвлөл, 486 сурагчдын төлөөллийг оролцуулан хийсэн.

Архивын тасаг: Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Татварын хэлтсийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын мөрөөр улсын байцаагчийн албан шаардлага, дүгнэлтийг гарган хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар Төрийн архивын байрны нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухайд мөн “Төрийн архив, албан

хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухайд хэлэлцүүлсэн.

Архивын лавлагаа, мэдээллийн /e-archives.gov.mn/ системийн ашиглалтыг нэмэгдүүлж, 2023 оны 03 дугаар сард нийт 6 иргэнээс хүсэлт хүлээн авч, 13 архивын хуулбар гарган цаг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Цагдаагийн газар: 2023 оны 03 дугаар сард аймгийн хэмжээнд нийт 1420 гомдол мэдээлэл бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 452 буюу 46.7 хувиар өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй 437 гомдол мэдээлэл бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 70 буюу 19.0 хувиар өссөн бол зөрчлийн 983 гомдол мэдээлэл бүртгэгдэж урд оны мөн үеэс 382 буюу 63.5 хувиар өссөн. Нийт 189 гэмт хэрэг бүртгэгдэж, урьд оны мөн үеэс 44 буюу 18.8 хувиар буурсан бол нийт 13775 зөрчил бүртгэгдэж, урд оны мөн үеэс 5886 буюу 1.7 дахин өссөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: “Ёсолъё, хүндэлье, мэндэлье” 1 сарын аяныг албан хаагчдын дунд зохион байгуулж цэргийн хэргийн мэдлэгийг олгох дадлага, сургалтыг чанаржуулах, цэрэгжилт, жагсаалч байдлыг сайжруулсан.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас зохион байгуулсан “Дүрэмт хувцас бидний бахархал, дүрмээр өмсөх бидний үүрэг аян”-д нэгдэж, нийт албан хаагч сахилга ёс зүйн зөрчилгүй ажиллаж, олон нийтийн цахим сүлжээнд нийт 12 мэдээ, мэдээлэл байршуулж, 1321 хүнд байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нийт 764 төлбөрийн болон хүүхдийн тэтгэлгийн материалд явуулж, 40 материалыг дуусгавар болгож, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан 243 ялтан этгээдэд хяналт тавьж, энэ сард 58 хүний хяналт дуусгавар болж, одоо 207 ялтан этгээдэд хяналт тавин ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний алба: 2023 оны 03 дугаар сард гэмт хэрэг, зөрчлийн 28 дуудлага дээр Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, мөрдөгчийн тогтоолоор 73 удаагийн шүүх эмнэлгийн шинжилгээ хийж, үүнээс хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 69, цогцост задлан шинжилгээ 4, мөн криминалистикийн 14, тусгай шинжилгээ 22 хийж, гарын хээний дардас 65, шүүх гэрэл зураг 725 /үүнээс шинжилгээний 96, хэргийн газрын үзлэгийн 352, цогцсын үзлэг, задлан шинжилгээний 168, бусад 109/-г боловсруулж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс: 2023 оны 03 дугаар сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 151 /эрэгтэй-67, эмэгтэй-69/
- Гэрлэлтийн бүртгэл – 31
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 15
- Үрчлэлт - 4
- Эцэг, эх тогтоолт - 03 /үүнээс эрэгтэй 01, эмэгтэй 02/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 8
- Нас баралт - 48
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 271
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 118
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 63
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 210
- Гадаад паспорт олголт - 359

- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн - 141
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 1290 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 671
- Анхны бүртгэл - 19
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 103
- Барьцааны гэрээ - 511
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 13
- Лавлагаа хуулбар - 10
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо - 134

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 1715
- Анхны бүртгэл - 102
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 311
- Барьцааны гэрээ - 1173
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 40
- Лавлагаа хуулбар - 32

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлаг, спортын талаар: 2022-2023 оны хичээлийн жилд эхний болон тав, арав дахь жилдээ ажиллаж буй цэцэрлэгийн багш, удирдах ажилтнуудыг МДҮС-ын хуваарийн дагуу хамруулах ажлыг зохион байгууллаа.

АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй ахлах ангийн сурагчдад зориулсан манлайлагч бэлтгэх Олон Улсын Боловсролын FLEX хөтөлбөрийн шалгаруулалтад Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 10а ангийн сурагч Э.Сэлэнгэсайхан тэнцлээ.

Боловсролын ерөнхий газар болон “Дэлхийн мөрөөдлийн сургууль” НҮТББ хамтран хэрэгжүүлж буй “Дэлхийн Монгол охид” менторшип хөтөлбөрт сургууль тус бүрээс нэр дэвшүүлсэн 30 сурагчаас англи хэлний онлайн түвшин тогтоох тест авч 10 сурагчийг шалгаруулан хөтөлбөрт хамруулсан. Энэхүү хөтөлбөр нь 2023 оны 03 дугаар сарын 03-аас 04 дүгээр сарын 15-ныг хүртэлх хугацаанд хэрэгжих бөгөөд алслагдсан сум дүүргийн охидыг хилийн чанадад сурахад бэлтгэх, хилийн чанадад амьдарч, сурч буй амжилттай эмэгтэйчүүдээс зөвлөгөө сургалт авах, менторлуулах зорилготой хөтөлбөр юм.

Боловсролын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан “Хүүхдийн аюулгүй тээвэрлэлт ба хамгаалалтын суудал” цахим судалгаанд 10629 эцэг эхээс 3430 хамрагдсан.

Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд Боловсролын чанарын шинэчлэл төслийн “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дахь шатанд “Ухаалаг хэрэглээтэй бяцхан уншигч” төсөл хэрэгжүүлсний үр дүнд бий болсон “Унших чадвараа хөгжүүлэх-Бидний ном” нэртэй цахим болон цаасан хэлбэрийг хослуулсан өөрөө унших, сонсох гарын авлага бүтээн нээлтээ хийсэн. Энэ үеэр аймгийн Ерөнхий боловсролын 26 сургуульд “Тоглонгоо суралцъя”, “Эгра-Эгма арга зүй”, хэрэгжүүлсэн үр дүнгээ хэлэлцүүлэн туршлагаа хуваалцлаа.

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд

Ерөнхий боловсролын сургуулийн 7-9 дүгээр ангийн сурагчдын дунд “Монгол Улсын Зэвсэгт хүчин” ерөнхий сэдвийн хүрээнд гар зураг болон эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулахад хамтран ажиллаж, 100 гаруй бүтээлийг дүгнүүллээ.

Ерөнхий боловсролын 5-12-р ангийн сурагчдын дунд “Кэнгуру-2023” Олон Улсын математикийн уралдааныг зохион байгууллаа.

2022-2023 оны хичээлийн жилийн Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг зохион байгуулж, математик, физик, мэдээллийн технологийн олимпиадад 6-12 дугаар ангийн 290 сурагчид, 111 багш нарын нийт 401 хүн оролцон оюун ухаанаа сорилоо.

Даамын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн нэрэмжит болгон 3 насны ангиллаар (6-8 , 9-10, 11- 13, 14-16 зохион байгуулсан. Тэмцээнд 13 сумын 134 тамирчин оюун ухаанаа уралдуулан оролцлоо.

Аймгийн аварга шалгаруулах идэрчүүдийн гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж тэмцээнд аймгийн бүсүүдээс шалгарсан нийт 28 багийн 300 гаруй тамирчид оролцлоо.

2023 оны аймгийн аварга шалгаруулах Жүдо бөхийн өсвөр үеийн тэмцээнийг Мандал суманд зохион байгуулж, тус тэмцээнд 54 жинд 13 байгууллагын 310 тамирчид хурд хүчээ сорин өрсөлдлөө.

Чөлөөт бөхийн залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний анхны мөнгөн медальт, ОУХМ Санжаагийн Батсүх агсны нэрэмжит чөлөөт бөхийн 2023 оны U17 насны ангиллын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Сэлэнгэ аймагт зохион байгуулж, тэмцээнд хот, хөдөөгийн 34 багийн 500 гаруй тамирчин хөвгүүд, охидын тус бүр 10 жинд өрсөлдөв.

Эрүүл мэндийн талаар: Улсын гуравдугаар төв эмнэлэг, аймгийн Эрүүл мэндийн газрын хамтын ажиллагааны хүрээнд “Чадварлаг сувилагч солилцоо” ажлын байрны тав хоногийн сургалтыг 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл 8 ээлжээр зохион байгуулж, сургалтад Эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн албаны гишүүд болон анхан, лавлагаа шатлалын нийт 53 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг хамрагдлаа.

“Сувилагч-Зөв стандарт” ажлын байрны сургалтад 35 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг хамруулан ажиллалаа.

Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх, сувилагчдын мэргэжлийн болон сувилагчийн ёс зүйн дүрмийг баримтлан, гардан үйлдлийн ур чадварыг нэмэгдүүлэх, MNS:4621:2008 стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, өрх, сум, тосгон, хувийн хэвшил, хилийн цэргийн анги, хорих ангийн нийт 35 сувилагчийг зургаан ээлжээр хамруулан, сувилагч нараас гардан үйлдлийн өртөөчилсөн үнэлгээг авч ажиллалаа.

Алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдэд “Халуун сэтгэл-23” нүүдлийн эрүүл мэндийн үзлэгийг Ерөө, Жавхлант суманд зохион байгуулан ажиллалаа. Мөн сумын Эрүүл мэндийн төвд суурин баг байрлан сумын төвийн иргэдэд 7 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн тусламж үзүүлж нийт 1311 үзлэг, оношилгоог хийсэн байна. Алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдэд явуулын 2 баг 454 км-ыг туулан 3 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг,

2 төрлийн оношилгоо (зүрхний цахилгаан бичлэг, эхо)-г нийт 632 иргэнд үзүүлэн ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх ажлын хүрээнд Улсын төсвийн орлогоос Халамжийн санд тайлант хугацаанд 65386 иргэнд 16162545.7 мянган төгрөгийг, Орон нутгийн төсвийн орлогоос 8 иргэнд 9600.0 мянган төгрөгийг олгоод байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэхээр дараах үйлчилгээг иргэдэд үзүүллээ. Үүнд:

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан EJOB программд баяжилт хийж:

- Ажил олгогчийн мэдээлэл - 74
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд - 51 иргэн
- Идэвхтэй ажил хайгчаар - 367 иргэн
- Ажил зуучлах үйлчилгээнд - 33 иргэн
- Сул чөлөөтэй - 362 ажлын байрыг бүртгэж мэдээлсэн байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр 51 иргэнд үзүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг төрийн банкаар дамжуулан 14 иргэн, аж ахуй нэгжид 216000.0 мянган төгрөгийг олгож, 25 ажлын байрыг бий болгон ажиллалаа.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Улсын Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 5,463,906,300 төгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 8014286.62 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгөөс 7611812.21 мянган төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 94.98 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 18859 тэтгэвэр авагчдад 9789082.04 мянган төгрөгийг олголоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас 1119 даатгуулагчдад 672111.78 мянган төгрөгийн ХЧТА, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгосон.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас 174 даатгуулагчид 202306.30 мянган төгрөгийн тэтгэвэр, ҮО-ийн тэтгэмж, сувиллын зардалд олгосон байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 124 даатгуулагчдад 389843.90 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь энэ сард 4 удаа хуралдаж нийт 362 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 27 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоож 331 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 31 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар: “Дээрэлхэлтийн эсрэг үе тэнгийнхэн” сэдэвт аймгийн аварга шалгаруулах Карл Поррерын мэтгэлцээний тэмцээнийг үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхал, хүчирхийллийг зогсоох, урьдчилан сэргийлэхэд олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, дээрэлхэлтийн эсрэг үе тэнгийнхнээр нь дамжуулан нөлөөлөх зорилгоор зохион байгуулсан тэмцээнд 17

сум, 6 тосгоны Ерөнхий боловсролын 9-12 дугаар ангийн 15 багийн нийт 45 сурагчид оролцсон.

Сумдын Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүдэд Хүүхдийн тусламжийн шуурхай удирдлагын багтай хамтран 108 утасны программ дээр ажиллах арга зүйн сургалтыг цахимаар зохион байгуулж, 23 хүн хамрагдсан.

Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, гарц шийдлийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хамгаалахад салбар бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Нэгдүгээрт хүүхэд” Хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хурлыг зохион байгуулж, 60 албан хаагч хамрагдлаа.

Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан нийт 5 хүүхдэд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, сэтгэл зүйн тест авч ажилласан.

“Нэг тэрбумаараа тэмцье” Олон Улсын хөдөлгөөнийг охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг таслан зогсоохын төлөө дуу хоолойгоо өргөн “Алхалт” арга хэмжээ зохион байгууллаа.

Монгол Цэргийн баяр, Зэвсэгт хүчин байгуулагдсаны 102 жилийн ойг угтан “Цэргийн нэг өдөр” арга хэмжээг Хилийн цэргийн 0101-р ангийн хамт олонтой хамтран зохион байгуулж, арга хэмжээнд “Миний эх орон- Миний бахархал” сэдэвт эссэ бичгийн уралдааны шалгарсан 5 сурагч, Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх “Хөвгүүдийн клуб”-ын гишүүдийн төлөөлөл оролцлоо. Мөн арга хэмжээний талаарх видео бичлэг бэлтгэн цахим хуудсаар түгээсэн.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Тосны ургамал тариаланчдын хаврын зөвлөгөөн”-д аймгийн төлөөлөл 40 гаруй тариаланчид оролцлоо.

“Хөгжлийн шийдэл” ТББ-ын “Бэст хөтөлбөр”-тэй хамтран Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх болон Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн болон төсөл боловсруулах талаарх зөвлөгөө мэдээллийг өгөх сургалтыг Баянгол, Мандал, Сайхан, Ерөө, Хүдэр, Жавхлант суманд зохион байгуулж, сургалтад 110 гаруй жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэд оролцлоо.

Тариалангийн бүс нутагт үржүүлж буй мал аж ахуйг эрчимжүүлэн эрүүлжүүлэх, малын тоог бэлчээрийн даацад тохируулах чиглэлээр манай байгууллага “LBH” ХХК-тай хамтран инновац технологит суурилсан малын эрдэс нэмэгдэл тэжээлийн “Мимо шинэ технологи”-г хэрэгжүүлэхээр шинээр төллөх хургыг үе шаттайгаар “Мимо шинэ технологи”-оор бордох ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Эрдэс нэмэгдэл тэжээл болон шинэ технологийн хэрэглээг нэвтрүүлснээр мал амьтны эрдсийн дутагдлыг нөхөх, өвчлөлөөс сэргийлэн эрүүл Монгол малыг өсгөн үржүүлэх, зүй бус хорогдлыг бууруулах, нэгж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж эдийн засгийн үр өгөөжийг өсгөх бүрэн боломжтой боллоо.

Аймгийн хэмжээний нийт мал сүргийн 43,9 хувь буюу 888423 толгой эх мал төллөхөөс 3 дугаар сарын байдлаар гүү 60, үнээ 1435, эм хонь 57455, ямаа 58562 нийт 117512 толгой хээлтэгч төллөсөн нь мал төллөлт 14 хувьтай явж байна. Нийт гарсан төлөөс 412 төл зүй бусаар хорогдож төл бойжилт 99,2 хувьтай байна. Аймгийн хэмжээнд адуу 136, үхэр 512, хонь 748, ямаа 855 нийт 2251 толгой мал зүй бусаар хорогдоод байна. Үүнээс том малын хорогдол нийт сүргийн 1 хувийг эзэлж байна.

Бусад аймаг сумдаас манай аймагт отроор өвөлжиж, хаваржиж буй малчин, мал бүхий иргэдийг заасан хугацаанд багтан өөрийн аймаг руу буцах, мөн отор нүүдэл хийж байгаа малчин, мал бүхий иргэдэд бусдын өвөлжөө, хаваржаанд зөвшөөрөлгүй нүүдэллэхгүй байх, заасан газарт нутаглах талаар сумдад үүрэг чиглэл өгч ажиллалаа.

2022 оны жилийн эцсийн мал тооллогоор мал тоолуулсан иргэн аж ахуйн нэгжийн тоон мэдээллийг малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн системд шивж оруулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Аймгийн хэмжээнд 75 аж ахуйн нэгж 5543 малчин, 5025 мал бүхий иргэний мэдээллийг оруулахаас 82 хувьтай байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2023 оны “Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 08-00/01 удирдамжийн дагуу 17 сумын Мал эмнэлгийн төвийн улсын байцаагч нар урьдчилан сэргийлэх мал эмнэлгийн хяналт, шалгалтыг мал, амьтны гаралтай түүхий эд ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, борлуулдаг газруудад зохион байгуулсан.

Мал эмнэлгийн Ерөнхий газраас зохион байгуулсан “Мал эмнэлгийн хяналт шалгалт зохион байгуулах”, “Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, Мал эмнэлгийн нэгдсэн системийн хяналт, анхаарах асуудлууд”, “Эрт илрүүлэг арга хэмжээг зохион байгуулах”, цахим хурлуудад сумын Мал эмнэлгийн тасаг болон Мал амьтны эрүүл мэндийн албаны давхардсан тоогоор 48 мэргэжилтэн хамрагдсан.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 1450 кг үхрийн махны 8 дээж, 140 кг адууны 1 дээж нийт 9 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт, арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Преми-тестийг ашиглан антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээг хүнс болон тэжээлд антибиотикийн үлдэгдлийг илрүүлэх арга MNS 6665:2017 стандартын дагуу 28 сорьц дээж цуглуулан Ampicillin, Penicillin, Chloramphenicol, бүлгийн антибиотик байгааг илрүүлэх шинжилгээг хийж, уг бүлгийн антибиотууд зөвшөөрөгдөх хэмжээнээс бага буюу сөрөг дүнтэй байгааг тогтоосон.

Импортын 30 аж ахуйн нэгжийн 2.7 сая ширхэг өндөг, 282.8 тн гахайн мах, 102.5 тн гахайн өөх, 92 тн тахианы мах, 12.4 тн үхрийн махан котлет буюу 489.7 тн мах, махан бүтээгдэхүүний нийт 165 сорьц дээжид шинжилсэн.

Хушаат сумаас 1 эмгэгт дээжийг нян судлалын шинжилгээг хийж Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторид хариуг баталгаажуулахаар хүргүүлсэн. Зүүнбүрэн, Орхонтуул, Алтанбулаг сумын 145 дээжид ийлдэс судлалын шинжилгээг хийж Зүүнбүрэн сумын 1 адууны дээжийн хариуг баталгаажуулахаар Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторид илгээсэн байна.

Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораториос баталсан удирдамжийн дагуу санамсаргүй түүврийн аргаар 17 сумын 30 өрхийг хамруулан 480 сорьц дээжийг цуглуулж шинжлэх аймгийн Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний ийлдэс судлалын тандалт хийж, дээж цуглуулах ажил хийгдэж байна.

Сүхбаатар, Алтанбулаг сумын 2 адууны дээжид шимэгч судлалын шинжилгээ хийж *Strongylus equines*- ийн өндөг илрэв.

Мал эмнэлгийн лабораторийн цахим систем /vetlab.shinjilgee.mn/-д 11 хандалтын 33 сорьц дээжийг бүртгэсэн байна.

Цахим сургалт: “Эпидемиологийн үндсэн ойлголтууд, тандалтын цахим систем дээр асуумж үүсгэх” сэдэвт сургалт 2 эмч, 2023 оны Шүлхий болон Бог малын мялзан өвчний халдварын тандалт хийх, тандалтыг хэрхэн зохион байгуулах талаарх мэдээлэл хурал 2 эмч хамрагдсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Баянгол сумын Цагаанчулуутын орд “Сонортрейд” ХХК, Сайхан сумын Хөтөлийн цементийн орд “Цемент Шохой” ТӨХК, Хүдэр сумын Төмөртэйн төмрийн хүдрийн орд “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК зэрэг 3 аж ахуйн нэгж, байгууллагын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх техникийн нөхөн сэргээлтийн талбайн солбицлыг хүргүүлж, тусгуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулагдаж “Байгаль орчны салбарт шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, цаашид анхаарах асуудал”, “Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тавих хяналт” сэдвээр сум болон сум дундын Ойн ангиуд, Байгаль хамгаалагчид, Байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт мэдээлэл хийж зөвлөмж, чиглэл өгч ажиллалаа.

Уг арга хэмжээний үеэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нартай 2023 онд хяналтыг хэрэгжүүлэх тухай хариуцлагын гэрээ байгуулж ажиллалаа.

Энэ хугацаанд зохих зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг хуш модны самар бэлтгэсэн 4 иргэнд холбогдох зөрчилд нийт 1.2 сая төгрөгийн торгууль, 3,9 сая төгрөгийн нөхөн төлбөр тооцож 283 кг самар, мөн зохих зөвшөөрөлгүйгээр бэлтгэсэн бургасны мөчир буюу үржлийн материал /7 боодол буюу 600 ширхгийг тус тус хураан авч 500.0 мянган төгрөгийн торгууль, 192.5 төгрөгийн нөхөн төлбөр тооцож, Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн 1 иргэнд 50.0 төгрөгийн торгууль тус тус тооцож барагдуулан төсөвт нийт 5.9 төгрөгийг төвлөрүүлж ажиллалаа.

Хүдэр сумын 1 аж ахуйн нэгжид зохих зөвшөөрөлгүй мод бэлтгэсэн үндэслэлээр зөрчлийн хэрэг нээн шалгаж байна. Байгалийн нөөцийн хууль бус ашиглалтын зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр дээрх зөрчлүүдийг шалган шийдвэрлэх арга хэмжээ авлаа.

Мандал, Ерөө, Хүдэр, Баруунбүрэн, Сайхан, Алтанбулаг, Сүхбаатар, Цагааннуур, Түшиг сумдад мод бэлтгэх, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүх ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд болон уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан гарах эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн хангуулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр: Хот байгуулалтын кадастрын Урбан менежер цахим мэдээллийн санд 17 сум, 6 тосгоны нийт 1497 барилга байгууламж бүртгэгдсэн. Системийн өгөгдлийг шинэчлэх, баяжуулах ажлын хүрээнд Мандал сумын нийт 365 барилгын хаягжуулалтыг зассан байна.

Сант суманд баригдаж буй 100 ортой дотуур байрны барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллалаа. Барилгын дотор халаалтын системийг засах, хөлдсөн хагарсан халаах хэрэгслийг солих ажил хийгдэж байна.

Сайхан суманд “Чингисийн төгөл” ХХК-ий гүйцэтгэж буй нийтийн эзэмшлийн байрнуудын гадна фасадны засварын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллав. Засварын ажил эхэлсэн бөгөөд 32-р байрны дээвэр засварын ажил хийгдэж байна. Хуучин хар цаасыг хуулж, полимер мембран дэвсэж дээврийн салхивчийн малгайг солих ажил хийгдсэн.

Орхон суманд баригдсан 75 ортой дотуур байрны чанарын баталгааны хугацаа дууссан тул барилгад үзлэг шалгалтыг хийж, барьцаа хөрөнгийг чөлөөлөх тухай гүйцэтгэгч “Бадрах мандал шим” ХХК-аас гаргасан хүсэлтийн дагуу барилга байгууламжид үзлэг шалгалтыг хийхэд барилгын үндсэн хийц бүтцэд гарсан ноцтой зөрчилгүй. Халаалтын системийн халаах хэрэгсэл зарим газруудад цоорсон тул гүйцэтгэгч байгууллагаар солиулахаар харилцан тохиролцож хурлын тэмдэглэл үйлдэж баталгаажуулсан.

Засгийн газрын 2021 оны 212 тогтоол “Барилга байгууламжийг ашиглалтад хүлээлцүүлэх дүрэм”-ийн дагуу доорх төсөл арга хэмжээнд дараах ажлуудад улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүллээ. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам”-ны захиалгаар Ерөө суманд баригдсан “1000 тн ногоо хадгалах зоорь”-ийн барилга угсралтын ажил,

2. Сүхбаатар сумын 3-р багт “ЭБУС” ХХК-ий хөрөнгө оруулалтаар баригдсан “Эмнэлгийн барилга”-ын ажил,

3. Иргэн Н.Энхчимэгийн захиалгаар Мандал суманд баригдсан “Худалдаа үйлчилгээний барилга”-ын угсралтын ажил

Орон нутгийн өмчийн чиглэлээр: Аймгийн 17 сумдын 2023 оны бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөг хянан баталгаажуулж Сангийн яаманд хүргүүлж, олон нийтэд нээлттэй нийтэлсэн.

3 дугаар сарын байдлаар захиалагчаас 34 ажлын зураг төсөв, ажлын даалгавар ирснээс ажлын тендер зарлагдаж хүлээн авах шатандаа байгаа 11, үнэлгээ хийж байгаа 7 ажил, үнэлгээний хороо байгуулах 5 ажил, гэрээ байгуулах эрх олгогдсон 4 ажил байна.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран тус сумын Б.Ренчиний нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн эрэгтэй сурагчидтай дээрх сэдвийн хүрээнд сургалт зохион байгууллаа. Сургалтаар эх орноо хайрлан хамгаалахын учир, Монгол цэргийн түүхэн уламжлал, цэргийн албаны тухай ойлголт түүний төрөл, хэлбэр, иргэний цэргийн үүргээ хэрхэн биелүүлэх, Эрдэм мэдлэгийг эрхэмлэх ирээдүйд нийгмийн өмнө хариуцлагатай эр хүн байх талаар сурагчидтай ярилцаж 35 сурагчийг хамрууллаа.

Монгол цэргийн өдрийг угтан Сумын Засаг даргын 2023 оны А/24 тоот захирамжаар иргэдийн дундах “МАРШ ТАКТИК” 2023 цэрэгжилтийн спортын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 7 баг оролцлоо.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны “Аюулыг авдарлая” аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас 40 кг аюултай хог хаягдал (Батарей, гар утас, цахилгаан хэрэгсэл гэх мэт) цуглуулсан.

“Иргэний хамгаалалтын сургалт”-д сумын ойн сан гэрээгээр эзэмшигч 13 нөхөрлөл, аж ахуй нэгжийн 16 ажилтан хамрагдлаа.

Мэргэжлийн хичээлийн олимпиадын 13 чиглэлээр тус сумын ерөнхий боловсролын сургуулийн 17 багш, 34 сурагч оролцож алт 2, мөнгө 1, хүрэл 4, тусгай байр 6 сурагч эзэлсэн амжилттай оролцлоо.

Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан 9-12 дугаар ангийн 170 сурагчдад “Сүрьеэ өвчнөөс сэргийлэх болон электрон тамхины хор уршиг” сэдвээр сургуулийн эмч, сэтгэлзүйч нар хамтран сургалт зохион байгууллаа.

Дэлхийн усны өдөрт зориулан 3-5 дугаар ангийн сурагчдын дунд уур амьсгалын өөрчлөлт, усны нөөц, усны үнэ цэнэ, усны өдөр тутмын зөв зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, усыг хайрлан хамгаалахад сурагчдын оролцоог нэмэгдүүлж, хөгжүүлэх зорилготой “Цэнхэр алт” сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж гар зургийн уралдаанд 180 гаруй хүүхэд өөрсдийн зурсан зургаар оролцлоо.

40-65 насны 1430 иргэдийг халдварт бус өвчнийг эрт илрүүлгийн үзлэгт хамруулахаас цусны даралт ихдэх өвчний эрт илрүүлэгт 106 иргэнийг хамруулж 7 хувь, чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгт мөн 1430 иргэнийг хамруулахаас 104 буюу 7 хувь, элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт 1463 иргэн хамрагдахаас 61 буюу 4 хувь хөх, умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт 181 эмэгтэйг хамрагдахаас 26 эмэгтэйг хамруулж 14 хувьтай байна.

Баруунбүрэн сүм:

Газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн цахим бүртгэлийн сангаар дамжуулан Хөдөө аж ахуйг дэмжих сангаас авах үр, шатахуун, хор, гербицид, техникийн захиалга өгөх заавар, зөвлөмж зөвлөгөө өгч ажиллаж байна.

Улсын чанартай автозам дагуу дайрагдаж, үхэж хорогдсон 21 толгой мал, амьтны сэг зэмийг цуглуулан ачиж, хогийн нэгдсэн цэгт заавар журмын дагуу халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж булж устгалаа.

1, 2 дугаар багийн нутаг дэвсгэр Налгай ар, Бургалтай, Тарвагатай, Бумбат зэрэг газруудад иргэдийн мод бэлтгэлийн үйл ажиллагаанд 2 удаагийн технологит хяналт шалгалт ажлыг зохион байгуулж, иргэдэд заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийн өдөр, Монгол цэргийн өдрийг угтан сумын Соёлын төвөөс сумын нийт иргэдийн дунд “Хайрт аав ээжтэйгээ” фото зургийн уралдааныг цахимаар зохион байгуулж фото зургийн уралдаанд хамгийн их хандалт авсан 6 оролцогчийг дурсамж, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа.

Монгол Улсад зэвсэгт хүчний салбар үүсэж хөгжсөний 102 жилийн ой “Цэргийн баяр”-т зориулан үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх, сурталчлах, залуу хойч үе, хүүхэд багачуудад таниулах, зорилгоор “Орхон бүсийн аварга шалгаруулах өсвөр үеийн үндэсний бөхийн барилдаан”-ыг зохион байгууллаа. Тус бөхийн барилдааныг газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч Ж.Өлзийбаатар захиралтай “Бүрэн сэлэнгэ” ХХК, Н.Эрдэнэцогт

захиралтай "Бүрэн тариа" ХХК-иуд ивээн тэтгэж өсвөрийн бөхийн барилдаанд нийт 50 гаруй хүүхэд багачууд уран мэх, хурд хүчээ сорин барилдаж нас насны ангиллын үзүүр, түрүүгээ шалгарууллаа.

Баянгол сүм:

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Аз жаргалтай эмэгтэйчүүд", "Одонтой ээжүүд", "Ижийдээ захидал бичээрэй" уралдаанд 630 иргэнийг хамрууллаа.

"Хөдөлгөөн эрүүл мэнд" уриан дор нийтийн бүжгийн 5 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 220 иргэн, Соёлын сайдын 2023 оны "Музейн нээлттэй өдөр зохион байгуулах тухай" А/34 тоот тушаалын "Музей үзэх гоё" Орон нутаг судлах танхимын үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг 4 удаа зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 85 суралцагч тус тус хамрагдлаа.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин" бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд "Бүх нийтийн хог цэвэрлэгээ"-г зохион байгуулж 10 байгууллагын 158 албан хаагч, 25 аж ахуй нэгжийн 38 ажилтан, 3 багийн 52 айл өрхийн 108 иргэн оролцож 4 тн хогийг түүж, тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажиллалаа.

Дэлхийн усны өдрийг "Өөрчлөлтийн хурдасгая" уриан дор тэмдэглэн өнгөрүүлж Улсын хэмжээнд усны талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг цахимаар сурталчлан ажиллалаа.

Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Өсөх ирээдүйтэй бөх"-ийн тэмцээнийг 3-5 насны 35 хүүхдийг хамруулан насны ангиллаар зохион байгууллаа.

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх хэлтсээс "Анзаар" нөлөөллийн арга хэмжээний хүрээнд "Хар тамхины хор хөнөөл" сэдэвт сургалтыг зохион байгуулж төр төсвийн байгууллагын 150 ажилтан албан хаагч хамрагдлаа.

Ерөө сүм

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сумын эмэгтэйчүүдэд зориулсан хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, төрийн зүгээс эмэгтэйчүүдэд хандаж хийгдсэн ажлуудыг танилцуулан, Сэлэнгийн долгио чуулгын уран бүтээлчдийн тоглолтыг толилууллаа.

Монгол Улсын Зэвсэгт хүчний 102 жилийн ой, Монгол Цэргийн өдөрт зориулан төр, төсвийн байгууллага иргэдийн дунд "Эрчүүд" тэмцээнийг хоёр үе шаттай зохион байгуулж дөрвөн баг тамирчид өрсөлдөн 1 дүгээр байранд Засаг даргын Тамгын газрын хамт шалгарлаа.

"Ажлын байрны харилцаа" сэдвээр сумын Засаг даргын Тамгын газрын 22 албан хаагч, Ерөнхий боловсролын сургуулийн 25 багш, ажилчдад сургалт зохион байгууллаа. Мөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, "Тунараа хүний хөгжил төв", Энерги ухамсар судлалын доктор П.Тунараатай хамтран "Стресс менежмент, өөртөө итгэх итгэл", "Хүний хөгжил ба аз жаргал" сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад Засаг даргын Тамгын газрын 14 албан хаагч, 185 иргэн хамрагдлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан "Хамтдаа хөгжье" өдөрлөгийг зохион байгуулж, 25 иргэн оролцсон ба Эрүүл мэндийн тухай хууль, "Сайн дурын даатгалын ач холбогдол", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж

хөнгөлөлт, “Халдварт бус өвчнөөс сэргийлэх”, “Эмийн зохистой хэрэглээ” сэдвээр тус тус мэдээ, мэдээлэл хүргэж гарын авлага тарааж ажиллалаа.

Сүрьеэтэй тэмцэх үйл хэрэгт олон нийтийн анхаарлыг хандуулах болон хүн бүрийн оролцоо чухал гэдгийг сурталчлан таниулах, мэдлэг олгох зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн 212 сурагчдад “Сүрьеэ өвчний ерөнхий ойлголт”, “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт зохион байгууллаа.

ОХУ-ын БНБУ-ын Зэдийн районы Соёл урлагийн газартай байгуулсан гэрээний дагуу Ерөө, Жавхлант, Алтанбулаг, Зүүнбүрэн, Баруунбүрэн сумдын Соёлын төв, Хөтөл Соёлын ордны уран бүтээлчидтэй хамтран 65 хүний бүрэлдэхүүнтэй “Монгол түмний дуулал” урлагийн тоглолтыг Зэдийн район, Дэтөр, Дээд Учотээ, Алцаг зэрэг тосгонд толилууллаа.

Жавхлант сум:

Сумын төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, “Ажлын байрны харилцаа”, “Иргэнд хүрсэн төрийн үйлчилгээ-ёс зүйтэй төрийн албан хаагч” сэдвээр тус тус илтгэл тавьж, 2022 оны үйл ажиллагааны үр дүнгээр аймгийн “Тэргүүний сум”-аар шалгарахад төрийн албан хаагч бүрийн үүрэг их байсныг дурдан төрийн албан хаагчдад талархал илэрхийллээ.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, “Ээжийгээ баярлуулъя” гэр бүлийн гар бөмбөгийн тэмцээн, “Уран бэр” үзэсгэлэн, “Ижидээ захидал бичээрэй” уралдаан, “Ээжтэйгээ хамт” зургийн уралдаан, “Одонтой ээжүүдээрээ бахархацгаая” хүндэтгэлийн арга хэмжээ, “Ижидээ өргөх дуун цацал” тоглолт, үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа. Мөн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын уран бүтээлч МУСТА, Алтан гадас одонт Б.Цолмон “Би хайртай” тоглолтоо толилууллаа.

Сумын Засаг дарга ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчидтай уулзаж, мэргэжил сонголтоо хэрхэн зөв хийх талаар ярилцан элсэлтийн ерөнхий шалгалтад нь амжилт хүсэж, Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайд, УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын “Шинэ алхам-2023” номыг гардуулан өглөө.

Сумын удирдлагын баг, төр төсвийн байгууллагын дарга нар, Төрийн албан хаагчдын төлөөлөл цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэх, иргэдийн санаа бодлыг сонсон ажил үйлчилгээндээ хэрэгжүүлэх зорилгоор 20 төрийн албан хаагчдыг 10 хэсэгт хуваарилан 2 хүний бүрэлдэхүүнтэй баг а/ Иргэдийг цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, б/ Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, в/ Жавхлантын мэдээ сонин тараах, д/Төр төсвийн байгууллагууд болон ЗДТГ-ын албан хаагчдын талаар үнэлэлт дүгнэлт авах ажлыг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа. Сумын төвийн 167 өрх хамрагдсан.

Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан сумын аварга шалгаруулах “Үндэсний бөх”-ийн барилдаанд сумын заан Н.Төртүвшин түрүүлж, шилжин явах цомын эзэн, сумын заан Э.Энхтүвшин үзүүрлэж, сумын заан Б.Наянжаргал, Б.Бат-Эрдэнэ нар шөвгөрлөө.

Ерөнхий боловсролын сургуулийн 11-р ангийн сурагчдын дунд "Мэргэжил бүхэн сайхан, түүний үнэ цэнэ" ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цуврал сургалтыг сумын насан туршийн боловсролын нэгжийн багш Т.Мөнхмаа, “Шинэ үе

хамтын холбоо” ТББ-ын лектор Ц.Баянжаргал нар явуулж, 201 суралцагч, 25 багш хамрагдлаа.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас 1-5 ангийн эцэг эхчүүд, сурагчдын дунд “Хүүхдэдээ чанартай цаг гаргацгаая” сургалтыг зохион байгуулж, 53 эцэг, эхчүүд, 187 сурагчид оролцсон.

Зүүнбүрэн сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит хуралдаанаар

1. Сумын засаг даргын 2021-2024 оны “Өрхийг дэмжих өсөлтийн бодлого” үйл ажиллагааны хөтөлбөр,
2. 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө,
3. Зүүнбүрэн сум байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг байгуулах тухай
4. Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны тухай асуудлууд
5. Ойгоос мод бэлтгэх газар, хэмжээ тогтоох тухай
6. Амьжиргаа дэмжих зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай асуудлыг хэлэлцлээ.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг 100 одонтой эхийн уулзалт арга хэмжээг УИХ-ын гишүүд, Эмэгтэйчүүдийн холбоо, Ахмадын холбоотой хамтран “Одонтой ээжүүдийн манлайлал” урианд дор зохион байгууллаа.

Мандал сум:

Мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж байгаа ажил үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээллийг албан ёсны цахим хуудсаар дамжуулан зурган болон видео хэлбэрээр 65 мэдээ, мэдээллийг бэлтгэн байршууллаа.

E-mongolia цахим мэдээллийн сангаас 1,2 дугаар шатлалт 113 лавлагааг иргэдэд гарган өгч үйлчиллээ.

Аймгийн Засаг даргын 2023 оны “Техникийн үзлэг зохион байгуулах тухай” А/06 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган 2023 оны тээврийн хэрэгслийн техникийн улсын үзлэгийг зохион байгууллаа.

Монгол цэргийн өдөр, орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ойн баярын хүрээнд сумын Засаг даргын нэрэмжит МАРШ ТАКТИК нэгдсэн арга хэмжээг хууль хүчний байгууллагуудтай хамтран 3 төрлөөр зохион байгуулж аваргуудыг шалгарууллаа.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх өсвөр үе хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах, иргэд олон нийтийн мэдлэг, ойлголт, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас зарласан “АНЗААР” аяны нэгдсэн арга хэмжээг, сумын ГХУСАЗСЗ, сундын дундын цагдаагийн хэлтэс хамтран төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгж байгууллагын 1600 албан хаагч, ажилчдыг хамрууллаа.

Казак үндэсний “Наурыз” буюу “Нарны баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүллээ. Статистик тоон үзүүлэлтээр Мандал суманд 417 Казак иргэн бүртгэлтэй байгаа ба сумын нийт хүн амын 1,5 хувийг эзэлж байна. 0-14 насны 122 хүүхэд, 15-54 насны 243, 55-аас дээш насны 52 иргэн аж төрөн амьдарч байна.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам 450 гаруй иргэд, сонгогчидтой уулзалт хийж 2020-2023 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, хэлэлцэн баталсан онцлох

хууль тогтоомжийг танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч санал солилцлоо. Уулзалтын үеэр гишүүний зүгээс боловсролын салбарт СӨБ-ын хүрээнд хэрэгжүүлж байгаа СТИЙМ төслийг “Мандал” 3 дугаар цэцэрлэгт хэрэгжүүлэн хувиасаа 20 сая төгрөгийн өртөг бүхий тоглоом, оюуны их спорт шатрын спортыг хөгжүүлэн ажилд дэмжлэг үзүүлэн сумын 3 шатрын клубт нийт 30 шатар, Хэрх Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн эмчилгээнд шаардлагатай хяналтын монитор, тариа болон дуслын автомат шахуургыг тус тус хүлээлгэн өгсөн юм.

“Эрүүл шүд-2024” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд сумын Нэгдсэн эмнэлгийн шүдний тасаг нь амны хөндийг эрүүлжүүлэх зорилгоор үзлэгийн нэмэлт цаг гарган амралтын өдрөөр 2 гэрээт эмчийг нэмэлтээр ажиллуулж байна.

БНСУ-ын “TOP-OASIS” Co.Ltd компани сумын Засаг даргатай хамтын боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, бизнесийн салбарыг хамтран хөгжүүлэх, гэрээт ажилтан ажиллуулах, сургалт сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах чиглэлтэйгээр талууд санамж бичигт гарын үсэг зурлаа. Уг арга хэмжээний хүрээнд мэргэжлийн боловсролын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр хамтран ажиллах гэрээг Зүүнхараа Политехникийн коллежийн захирал Ц.Эрдэнэчулуунтай хийж талууд баталгаажуулан үзэглэлээ.

Сумын 9 багийн хадлангийн талбайгүй, өвсгүй малчин, мал бүхий 340 өрхөд 1800 боодол өвсийг сумын аюулгүйн нөөцийн фондны өвснөөс үнэ төлбөргүй олгож малчдад дэмжлэг үзүүллээ.

Аймгийн Хоршоодын холбооны 20 жилийн ойн өдрийг угтан “Хоршоод хамтдаа” 2023 үйл ажиллагааг 15 сумын 36 хоршоодын 170 гаруй хоршоочдын сургалт, нөхөрсөг тэмцээнийг 2 өдрийн турш зохион байгууллаа.

Хоршоог хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн төслийг хүлээн авч 13 төсөл хэрэгжүүлэгчид нийт 215,0 сая төгрөгийг олгохоор батлагдлаа.

Орхон сүм:

Цаг агаарын болон хаваржилтын бэлтгэл байдлыг хангах зорилгоор тус сумын 1 болон 2 дугаар багийн 141 өрхөд сумын нөөцийн өвснөөс 2820 боодол өвсийг хөнгөлөлттэй үнээр олголоо.

Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний түүхт 102 жилийн ой, Монгол цэргийн баярыг тохиолдуулан сумын Засаг даргын 2023 оны “Нийтийг хамарсан тэмцээн, уралдаан зохион байгуулах тухай” А/05 тоот захирамжийн хүрээнд “Марш тактик” тэмцээнийг зохион байгуулж төр, төсвийн байгууллага, иргэдийн 4 баг оролцлоо.

Сумын угтах хаалганы ойр орчим болон төв зам дагуух 2 га талбайн 2 тн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, төвлөрсөн хогийн цэгт буулгалаа.

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн цахим программаар дамжуулан улаан буудайн үрийн захиалгын хүсэлтээ авах болсонтой холбогдуулан үрийн буудайн захиалга өгсөн 18 аж ахуйн нэгж, 4 иргэнд мэдэгдэл хүргүүлж ажиллалаа.

Орхонтуул сүм:

3 дугаар сарын байдлаар Хоршоо хөгжүүлэх сангийн 100131055401 тоот дансанд 8596746 төгрөгийн орлого орж, гэрээний хугацаа дуусаж зээлээ төлсөн 1 иргэн байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдэх Баянцогт 2-р багийн 2 орцтой орон сууцны барилгын дээвэр засвар, орцны хаалга шинээр солих, Баянцогт 2-р багийн 1 орцтой

орон сууцны барилгын дээвэр засвар, орцны хаалга шинээр солих, Баянцогт 2-р багт Хогны машин худалдан авах, Рашаант тосгонд Хогны машин худалдан авах, сумын Эрүүл мэндийн төвд шинжилгээний тоног төхөөрөмж худалдан авах ажлуудын тендерийг зарлаад байна.

Тайлант сард 39 мал эмнэлгийн гэрчилгээ бичигдсэнээс адууны мах 310 кг, үхрийн мах 1040 кг, хонины мах 3150 кг, ямааны мах 518 кг, тэмээний мах 470 кг, үхрийн сүү 11700 литр, ямааны гэдэс 15, ямааны толгой 15, Амьдаар: Адуу 4, Үхэр 2, Хонь 40 толгой, үржилд Адуу 7, Үхэр 4 тус тус бичигдсэн байна.

Сайхан сум:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 86 тоот “Үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай” тогтоолын дагуу Баруунбүрэн сумтай 2023 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай мод түлээ бэлтгэх гэрээг байгуулж, гэрээгээр хэрэглээний зориулалтаар арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоор шинэс 1500 м3, түлээний зориулалтаар шинэс 1330 м3 модыг тус тус бэлтгэхээр болов.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 118 дугаар тогтоолын дагуу 2022 онд суманд хүнсний ногоо тариалж иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад худалдан борлуулсан иргэдийн хүнсний ногооны урамшууллын материалыг бүрдүүлэн “Газар тариалангийн нэгдсэн систем”-д бүртгэн ажиллаж байна. Хөдөө аж ахуй дэмжих сангийн Хөтөл салбараас 2023 оны хаврын тариалалтад хэрэглэх Улаан буудайн үрээс хэсэгчлэн дээж авч шинжилгээнд хамруулав.

Сумын хэмжээнд том малын зүй бус хорогдол байхгүй, мал төллөлт 22 хувьтай буюу сумын хэмжээнд 64256 хээлтэгч мал төллөхөөс 14086 төллөж 14061 бойжсон. Төлийн хорогдол нийт 25 гарсан байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний 102 жилийн ой “Монгол цэргийн өдөр”-ийг угтан ерөнхий боловсролын 1-5 дугаар ангийн сурагчдын дунд “Монгол цэрэг” сэдвийн хүрээнд гар зургийн уралдаан, 6-11 дүгээр ангийн сурагчдын дунд “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” сэдвийн хүрээнд эсээ бичлэгийн уралдаан, Сайхан суманд үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн болон аж ахуйн тооцоот газар, банк санхүүгийн байгууллагын эрэгтэй албан хаагчдын дунд “Гар бөмбөг”-ийн зохион байгуулж тус арга хэмжээнд 8 баг тамирчид оролцсон.

“Бид ирээдүйн архи, тамхигүй нийгмийг бүтээж чадна” сэдвийн дор сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, сургалтаар электрон болон энгийн тамхины хор уршгийг таниулах, хүүхдийг тамхинд донтохоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн 102 суралцагчийг хамрууллаа.

Сум дундын Цагдаагийн хэлтсийн хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн, Цагдаагийн дэслэгч Б.Лхагважаргалтай хамтран ерөнхий боловсролын дунд болон ахлах ангийн сурагчдад “Үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг зогсоох, урьдчилан сэргийлэх зөвлөгөө” зохион байгуулан ажиллалаа.

Сант сум:

Мал төллөлтийн явцын мэдээгээр 49693 эх мал төллөхөөс 3 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар гүү 109, үнээ 665, хонь 14941, ямаа 9555 бүгд 25270 эх мал төллөж, мал төллөлт 50,8 хувьтай байна. Төлийн хорогдолгүй.

Сумын хэмжээнд төмс, хүнсний ногоо тариалж буй аж ахуйн нэгж, иргэдийн талбай болон зоорины судалгааг гаргаж, судалгаагаар 1 га хүртэл талбай эзэмшдэг

27 иргэн, 1-5 хүртэл га талбай эзэмшдэг 79 иргэн, 5-10 хүртэл га эзэмшдэг 23 иргэн, 10-аас дээш га газар эзэмшдэг 5 иргэн, нийтдээ 134 иргэн 483,3 га талбайд, 4 аж ахуйн нэгж 85 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж байна. Нийт 35 энгийн болон нүхэн зоорь ашиглагдаж байгаагаас хучилттай 342 тн багтаамж бүхий 10 зоорь, 338 тн багтаамж бүхий 25 ширхэг нүхэн зоорь байна.

“Хоршоо хөгжүүлэх сан”-гийн төсөл сонгон шалгаруулах хороо нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан 2023 оны тэргүүлэх чиглэлийн дагуу 10 иргэн, 1 дундын хоршооноос ирүүлсэн төслийг хүлээн авч 6 иргэн, 1 дундын хоршоонд нийт 131 660 000 мянган төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэлээ.

Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр “Мартын-8”-ны баярын өдрийг тохиолдуулан ЕБС-ийн 3-12-р ангийн сурагчдын дунд “Ээждээ унших миний шүлэг” цахим шүлгийн уралдааныг зохион байгуулан явууллаа. Уралдааныг 3-7-р анги, 8-12-р анги гэсэн 2 ангиллаар явуулж нийт 14 сурагч оролцлоо. Уралдаанд оролцсон хүүхдүүдийн бүтээлийг сумын “Ивэн голын хүүхдүүд” цахим хаягт байршуулан иргэдийн хүртээл болголоо.

Монгол Улсад Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ой, Монгол цэргийн баярыг тохиолдуулан уламжлал болон зохион байгуулагддаг “Жаран харын жаа” даалууны бооцоот тэмцээн, “Хөзрийн хаан” хөзрийн бооцоот тэмцээнүүдийг зохион байгуулж хөзрийн тэмцээнд 24 багийн 72 иргэн, даалууны тэмцээнд 18 иргэн оролцсон байна.

Сүхбаатар сүм:

Сумын Засаг даргын Тамгын газар харьяа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ОНӨААТҮГ-ын дарга, ӨЭМТ-ийн эрхлэгч, багийн Засаг дарга нартай “Удирдах ажилтны зөвлөгөөн-2023” арга хэмжээг зохион байгуулж сумын харьяа төр төсвийн удирдах албан тушаалтнууд сумын Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээг байгууллаа.

Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойг угтан бүх нийтийн “Үндсэн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт”-ыг аймгийн Засаг даргын Тамгын газар, “Иргэдийн шударга шүүх” ТББ-тай хамтран зохион байгуулж, төр төсвийн байгууллагын нийт 32 албан хаагч, 8 багийн 110 иргэн хамрагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам тус сумын 1-р цэцэрлэгт 19.0 сая төгрөгийн өртөг бүхий 101 нэр төрлийн эд анги тоглоомууд мөн багш, сурагчийн дэвтэр, эцэг эхийн үнэлгээний хуудас гэх мэт Steam kinder тусгайлсан хөтөлбөрөөр хүүхдийн сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, эрүүл мэндэд хор нөлөөгүй, орчин үеийн дэвшилтэт сургалтын хэрэглэгдэхүүнийг гардуулан өглөө. Steam хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2-5 насны хүүхдүүдийн математик сэтгэлгээ, техникийн авьяас чадварыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Мөн “Эмнэх баг”, “Номт хан” өрхийн эрүүл мэндийн төвд яаралтай үеийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай хяналтын монитор, тариа болон дуслын автомат шахуурга хүлээлгэн өгсөн.

Аймгийн аварга шалгаруулах “Шагай харваа” тэмцээнийг угтан Сүхбаатар сумын аварга шалгаруулах Шагайн харвааны тэмцээнийг сумын Засаг даргын ивээл доор зохион байгууллаа. Тэмцээнд Дархан-Уул аймаг, Алтанбулаг, Хушаат сум, Ерөө сумын Бугант тосгоны нийт 10 багийн 100 гаруй тамирчид өрсөлдлөө.

Аймгийн Эрүүл мэндийн газар, JCI “Амьдрал бэлэг” төслийн баг хамтран зохион байгуулсан элэгний В,С,D вирустэй, элэгний эмгэгтэй иргэдэд зориулсан

сэтгэл зүйн тусгай сургалтад 185 иргэнийг хамруулсан. Мөн уг төслийн баг тус сумын ерөнхий боловсролын 9-12 ангийн сурагчдад “Мэргэжил сонголт, хувь хүнийг хөгжил” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Түшиг сум:

Олон Улсын “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд амжилт бүтээлээрээ олондоо үлгэрлэн ажиллаж, амьдарч байгаа ээжүүд, эмэгтэйчүүдийг өргөмжиллөө.

- “Өндөр ээж”-ээр А.Булган
- “Буянтай ээж”-ээр Ч.Хашхүү
- “Энэрэлт ээж”-ээр Г.Одончимэг
- “Авьяаслаг эмэгтэй”-ээр Б.Анхцэцэг
- “Уран эмэгтэй”-ээр Д.Алтанцэцэг
- “Оюунлаг эмэгтэй”-ээр Н.Буянтогтох
- “Манлайлагч эмэгтэй”-ээр Б.Уранчимэг
- “Хөдөлмөрч эмэгтэй”-ээр Ц.Бямбаахүү нар тодорлоо.

Мөн “Ардын Хувьсгалын 100 жилийн ойн медаль”-иар С.Сэлэнгэ, Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр Л.Оюунцэцэг, сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр Л.Чимгээ нар шагнагдлаа.

Монгол Улсад Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жил, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан иргэд, залуучуудын дунд “Хугацаат цэрэг-цэргийн андууд” уулзалтыг зохион байгуулж, цэргийн албаа хаасан, одоо хааж буй иргэдийн төлөөлөл 50 гаруй иргэн, хугацаат албан хаагчид оролцлоо. Мөн “Хүчний тэмцээн”, “Хүүхдийн бөхийн барилдаан”-ыг явуулж, Д.Нэргүй агсны үр хүүхдүүдээс “Ааваа дурсана” дууны тэмцээнийг явууллаа.

Сумын хэмжээнд нийт 26032 толгой мал төллөхөөс төл бойжилт 996 буюу 26,1 хувьтай, малын зүй бус хорогдол байхгүй, мал төлөлт, бойжилт хэвийн явагдаж байна.

Хар горхид “Шинэбадрах” ХХК үйлдвэрлэлийн зориулалтаар 2 талбайд мод бэлтгэх талбай тусгаарлалт хийж 406 м3 мод бэлтгэсэн бөгөөд мөн 2022 онд бэлтгэсэн байсан 346 м3 нарыг тээвэрлэлээ. “Мойлт нуга” ХХК үйлдвэрлэлийн зориулалтаар нарс 1 талбайд 250 м3, шинэс 1 талбайд шинэс 240 м3 бэлтгэсэн.

Улаанбаатар Төмөр замын мод боловсруулах үйлдвэр шинэс 5 талбайд бэлтгэж, үйлдвэрлэлийн зориулалтаар 1300 м3, цэвэрлэгээний зориулалтаар 300, арчилгааны зориулалтаар 300 м3, “ММЭ Түшиг” ХХК 2 талбайд 400 м3 шинэс мод бэлтгэж, сумын дүнгээр 4 мэргэжлийн байгууллага 3196 м3 хэрэглээний модыг бэлтгэж, тээвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажиллалаа.

Мөн Улаанбаатар Төмөр замын мод боловсруулах үйлдвэртэй хамтран өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн 37 өрхөд түлээний модны тусламжийг үзүүллээ.

Хушаат сум:

Төрийн албан хаагчдыг ажлын байран дээр чадавхжуулах, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах, харилцаа хандлага, ёс зүй, эерэг сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой “Эерэг сэтгэлгээ хувь хүний хөгжил” сургалтын багц хөтөлбөрийн хүрээнд төрийн захиргааны болон төсвийн байгууллагын албан хаагчдад “Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нь”, “Манлайлал”, “Хөгжлийн болон суралцахуйн бэрхшээлтэй

хүн гэж хэн бэ”, Үндэсний бичиг зэрэг сургалтад 97 төрийн албан хаагчийг хамрууллаа.

“Аз жаргалтай амьдрал” 2 сарын аяны хүрээнд согтууруулах ундааны хэрэглээг хянах, иргэдэд нөлөөлөх чиглэлээр зохион байгуулагдах сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд “Эр хүний ноён нуруу” сургалтад 14 иргэнийг хамрууллаа.

Хоршоо хөгжүүлэх сангийн төслийг хүлээн авч 16 төсөл ирснээс 6 төсөл шалгаран 102,000,000 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор боллоо.

Хүдэр сум:

Тайлант онд сумын төсвийн болон ОНХС-ийн 2,336,400,000 төгрөгийн 11 хөрөнгө оруулалтын ажил хийгдэхээс 3 дугаар сарын байдлаар зураг төсөв хийгдэж буй 5 ажил, зураг төсөв хийгдээгүй 1 ажил, шууд гэрээ байгуулах 5 ажил байна.

Тус сумын хэмжээнд 38771 тоо, толгой мал өвөлжиж, өвөлжилтийн байдал хэвийн малын хорогдол гараагүй байна. Нийт 17165 тоо толгой хээлтэгч мал өвөлжиж байгаагаас сумын мал төллөлт 15 хувьтай, төлийн хорогдол гараагүй.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Монгол гэр бүлийг алдаршуулах төв”-тэй хамтран “Дархан бэр”-ийг алдаршуулах үнэмлэх тэмдгийг 3 иргэнд гардуулав.

Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр “Хэрсүү гурвалжин” орон нутагтаа зохион байгуулж худаг, дэлгүүрийн худалдагч, хөрш гурвын холбоо хяналтыг сайжруулах зорилгоор хүүхэд хүчирхийлэлд өртсөн байна уу, нүд ам нь хөхөрсөн, ус авахдаа доголж бэртсэн байна уу гэдгийг хэрсүү ажиглан мэдэж 107, 108 утас руу дуудлага өгч хүүхдийг хамгаалах зөвлөмжийг хамтарсан багийн гишүүд 125 иргэнд танилцуулж 356 гарын авлага тараагдсан байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 онд ойгоос бэлтгэх үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний мод түлээний шинэчилсэн хуваарь батлах тухай” 16 дугаар тогтоол, сумын Засаг даргын 2023 оны “Ойгоос мод бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулах тухай” А/05 дугаар захирамжийн дагуу Тарвагатай 1-р багийн нутаг дэвсгэр болох Янгаахай, Бүдүүн, Оохор чиглэлд мод бэлтгэлийн талбай тусгаарлалт хийгдсэн газруудад хөдөлгөөнт эргүүл шалгалтыг 2 удаа хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын явцад “Хүдэр хөгжил”, “Тарс” ХХК-иудын мод бэлтгэх тээвэрлэх хяналтын хуудсыг ойгоос мод бэлтгэх журмын дагуу хэрэглэж хэвших тухай зөвлөмж өгч ажилласан.

Мод бэлтгэлтэй холбогдуулан аж ахуй нэгж байгууллагын мод бэлтгэлийн талбайг Янгаахай, Бүдүүн, Хайя уул, Амж, Монгол алт, Сөдтэйн даваа, Зэлтийн нуруу, Бумбат чиглэлд 437 га газар талбай тусгаарлалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн ойн сангийн нөөцгүй Сүхбаатар сум, Шаамар сумдын түлээний модны талбай тусгаарлалтыг хийж хяналт тавин ажиллаж байна.

Цагааннуур сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 23 дугаар хуралдаан хуралдаж 2023 оны Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгох чиглэл тогтоож, Мал амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөг батлан хэлэлцсэн.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан сумын Эмэгтэйчүүдийн холбооноос “Софт” волейбол, “Шугаман бүжиг”-ийн тэмцээн, 99

ээжийн “Сүүн цацал өргөх ёслол”-ын ажиллагааг зохион байгуулсан. Мөн сумын эмэгтэй манлайлагч, удирдагч эмэгтэйчүүдийн дунд “Сумын хөгжилд эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг явагдаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгч Э.Саранчимэг “Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ” сэдвээр илтгэл тавьж, сэдвийн хүрээнд сум орон нутгийг хөгжүүлэхэд эмэгтэйчүүдийн манлайлал, тэдний оролцоо, боломжийн талаар санал солилцсон.

Сэлэнгэ бүсийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Олон Улсын ойн өдөр”, “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан “Байгаль хамгаалал-Бидний оролцоо” сэдэвт “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулж, “Тэргүүн байр”-ыг Түшиг сумын “Ногоон гараг” баг эзэлсэн.

Мөн Сэлэнгэ бүсийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын дунд нөхөрсөг тэмцээнийг 6 төрлөөр зохион байгуулж, багийн нийлбэр дүнгээр “Цагааннуур” сумын баг тамирчид тэргүүлсэн.

Сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагуудын санаачилгаар Тамгын газрын 1 өрөөг “Хүүхдийн өрөө” болгон тохижууллаа. Уг өрөөнд албан хаагчид ажлын цагаар хүүхдүүдээ түр байлган, хичээл хийх, тоглож наадах бүрэн боломжтой байхаар тохижуулж, 9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтад хийсэн.

Шаамар сум:

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийн өдрийг тохиолдуулан сум, тосгоны “Шилдэг эмэгтэйчүүд”- ээ 9 номинациар шалгаруулан, 2023 онд “Алдарт эх”-ийн одонгоор шагнагдах 9 ээжид одонгийн дээлийн өнгө бэлэглэж хүндэтгэл үзүүлсэн.

Мөн Монгол цэргийн өдрийг тохиолдуулан “Бид чадна” цэрэг, анхан шатны төрөлт тэмцээнд 5 байгууллага 55 иргэнийг хамруулан цэргийн анхан шатны мэдлэг, хүч тамир, яаралтай тусламж, урлагийн номероор өрсөлдүүлээ.

“Хөгжлийн шийдэл” ТББ-ын “BEST” хөтөлбөрийн хүрээнд “Түрээсийн хүлэмж” авсан 30 иргэн болон хүлэмжийн аж ахуй эрхлэх хүсэлтэй 15 иргэнийг хамруулан чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА